



Japan  
Fund for  
Poverty  
Reduction



## L3605/G9191 : MON48076 - ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

### АЖЛЫН ДААЛГАВАР

#### C2- ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙГ ЭРТ ИЛРҮҮЛЭХ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ, БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ БЭХЖҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

#### А. ТАНИЛЦУУЛГА

Монгол улс, Азийн хөгжлийн банктай зээлийн гэрээ байгуулж (Зээлийн дугаар 3605) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл” (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлэхээр зөвшилцөлд хүрсэн. Тус төсөл нь Монгол Улсын Засгийн Газрыг дэмжин Улаанбаатар хот болон аймгуудын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог дэмжиж үйлчилгээг сайжруулах зорилготой юм.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нь хөгжлийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог бүрдүүлэх ажлыг зөвлөх компанитай хамтран хэрэгжүүлэх юм. Үүнд “Азийн Хөгжлийн Банк ба түүний зээлдэгч зөвлөхийг ашиглах журам”-д заасны дагуу ХНХЯ нь зөвлөх компанийг сонгон шалгаруулна.

Төсөл нь (i) хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх (ii) хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх эрүүл мэндийн загвараас сэтгэлзүй-нийгмийн загвар руу шилжих, (iii) эрт үеийн оролцоог хангах эцэг эх - хүүхэд - багшийн хамтын оролцооны хөтөлбөрийг боловсруулах, зорилтот аймгуудад хэрэгжүүлэх хөгжлийн төвийн үйлчилгээний загварыг боловсруулах, (v) хөдөлгөөн засал, ахуй засал, хэл засал, орон зайн баримжаа олгох, нийгмийн ажил, ортопед техникч бэлтгэх сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

#### Б. ЗӨВЛӨХ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Зөвлөх үйлчилгээ дараах ерөнхий зорилтуудаас бүрдэнэ.

- **Зорилт 1.** Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;
- **Зорилт 2.** Эрт боловсролын хөтөлбөр (портеж)-ийг боловсруулж, хэрэгжүүлэх;
- **Зорилт 3.** Хөгжлийн төвүүдийн үйлчилгээний дизайныг боловсруулах, хөдөлгөөн засал, ахуй засал, хэл засал, орон зайн баримжаа олгох, нийгмийн ажил, ортопед техникч бэлтгэх сургалтын хөтөлбөрүүдийг боловсруул, уг хөтөлбөрүүдийг зохих боловсрол/эрүүл мэндийн байгууллагууд ашиглахад дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх;

#### 1. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛУУД

Зөвлөх үйлчилгээ дараах ажлуудыг хамрах боловч уг ажлаар хязгаарлагдахгүй:

**Зорилт 1-ийн хүрээнд:** Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;

- (i) Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцооны өнөөгийн орчин, гэрээр очих сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн /Портеж хөтөлбөрийг хамарна/ өнөөгийн нөхцөл байдал, ур чадвар ба мэдлэгийн талаар түргэвчилсэн үнэлгээ хийх;
- (ii) Хүүхдийн хөгжлийн үе шатны агууламж (ASQ) ба Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ-III (BSID-III) системийг нутагшуулах, хөнгөн, дунд ба хүнд хэлбэрийн ХБ-ийн хоцрогдлыг үнэлгээний норматив хэмжүүрийг тогтоох, Монгол улсад хэрэглэх ASQ ба BSID-III -ий талаарх гарын авлагыг боловсруулах; Эх үрсийн эрүүл мэндийн гарын авлагыг (Ягаан дэвтэр) ASQ-ийн нас тус бүрд уялдуулан боловсруулах;
- (iii) Шинээр боловсруулсан BSID-III, ASQ болон тэдгээрийн стандарт ажиллагааны заавар

- (SOPs)-ын туршилтыг хийх; ASQ болон BSID-III-ийн ашиглах эрхийг зохих байгууллагаас авахад зөвлөмж, дэмжлэг үзүүлэх;
- (iv) Хамтран оролцогч талуудтай зөвшилцөх замаар хүүхдийн ХБ-г эрт илрүүлэх, үйлчилгээнд холбон зуучлах, хэрэгжилтийг хянах тогтолцоог бий болгох, ASQ болон BSID-III-ыг хэрэглэх стандарт ажиллагааны заавар (SOP)-ыг боловсруулах;
  - (v) ASQ, BSID-III-ыг хэрэглэх сургалтын хөтөлбөрүүд, модуль, болон сургалтын материалуудыг боловсруулах, үүнд сургагч багш нарт зориулсан сургалтын өмнөх ба дараах мэдлэг шалгах тест, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэхэд оролцох хүмүүсийн ур чадвар, мэдлэгийн түвшинд суурилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах; сургалт зохион байгуулах;
  - (vi) Урт хугацааны тогтвортой хөгжлийг бүрдүүлэх зорилгоор улсын хэмжээний сургалтын байгууллагуудын сургалтын хөтөлбөрт ХБ-ийг эрт илрүүлэхэд чиглэсэн сургалтын багцыг хөтөлбөрт оруулахад зохих байгууллагуудад дэмжлэг үзүүлэх;
  - (vii) Төслийн аймгуудад ХБ-ийг эрт илрүүлэх аргачлалын талаар олон нийтэд ойлголт өгөх, телевиз радиогоор шторк явуулах, олон нийтийн сүлжээгээр сурталчлан таниулах зэргийг багтаасан стратеги боловсруулах;

#### **Эрт илрүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх.**

- (i) ХБ-ийг эрт илрүүлэх тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой салбар зөвлөлийн (хүүхдийн комисс) үйл ажиллагааны зааварчилгаа, зохион байгуулалтын бүтэц, ажлын байрны тодорхойлолт/ажлын даалгаврыг хянаж, зөвлөгөө өгөх;
- (ii) ХБ-ийг эрт илрүүлэх шинэчилсэн тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой чадавхжуулах төлөвлөгөөг боловсруулж, салбар зөвлөлүүдэд сургалтууд, ажлын байран дах сургалтуудыг зохион байгуулах;
- (iii) ХБ-ийг эрт илрүүлэх тогтолцоог бий болгох, хянах, мэдээлэл сонгох, цуглуулах ба одоогийн мэдээллийн баазтай уялдуулж нутагшуулах, холбогдох төрийн албан хаагчдад мэдээллийг ашиглан илүү оновчтой шийдвэр гаргах чадвартай болоход нь дэмжлэг үзүүлэх;
- (iv) ASQ ба BSID-III нь Монгол улсын нөхцөлд хэр зохимжтой байх талаар үнэлгээ хийх хөндлөнгийн үнэлгээний багийн ажлын даалгаврыг боловсруулах; мөн сонгогдсон судалгааны багт техникийн зааварчилгаа өгөх.

#### **Зорилт 2-ын хүрээнд:** Эрт боловсролын хөтөлбөр (портеж)-ийг боловсруулж, хэрэгжүүлэх;

- (i) JICA START төслийн хүрээнд туршсан портеж сургалтын багцыг хянаж, нэвтрүүлэх бөгөөд холбогдох байгууллагуудаас портеж хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохиогчийн эрхийг авахад туслалцаа үзүүлэх;
- (ii) Төслийн аймгуудад портеж хөтөлбөрийг нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулах;
- (iii) Портеж хөтөлбөрт зориулсан үйл ажиллагааны удирдамжийг боловсруулах; портежийн үйлчилгээний ажилтнуудад зориулсан ажлын байрны тодорхойлолт болон ХБИ-ийн Хөгжлийн төвүүдэд портеж үйлчилгээг хэрэгжүүлэх зардлын тооцоог гаргах;
- (iv) Портеж хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хянах, мэдээлэл сонгох, цуглуулах ба одоогийн мэдээллийн баазтай уялдуулж нутагшуулах, холбогдох төрийн албан хаагчдад мэдээллийг ашиглан илүү оновчтой шийдвэр гаргах чадвартай болоход нь дэмжлэг үзүүлэх;
- (v) Портеж хөтөлбөрийн сургалтын хөтөлбөрүүд, модуль, болон сургалтын материалуудыг боловсруулах, сургагч багш нарт зориулсан сургалтын өмнөх ба дараах мэдлэг шалгах тест бүхий сургалтын гарын авлага; төслийн аймгууд дах холбогдох мэргэжилтнүүдэд сургалт явуулах;
- (vi) Хөдөлгөөнд тоглоомын номын сангийн талаар зөвлөмж боловсруулах; үүнд тоглоомын жагсаалт (эсхүл тоглох хэрэгсэл), техникийн нөхцөл ба үйл ажиллагааны заавар багтана;

#### **Зорилт 3-ын хүрээнд:** Хөгжлийн төвүүдийн үйлчилгээний дизайныг боловсруулах, хөдөлгөөн засал, ахуй засал, хэл засал, орон зайн баримжаа олгох, нийгмийн ажил, ортопед техникч бэлтгэх сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулах, уг хөтөлбөрүүдийг зохих боловсрол/эрүүл мэндийн байгууллагууд ашиглахад дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх;

- (i) ХБИ-ийн Хөгжлийн төвүүдийн үйлчилгээний дизайныг боловсруулах, үүнд ХБИ-дэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт, түүний хүрээ, үзүүлэх үйлчилгээний зохион байгуулалт, хүний нөөц, санхүүгийн нөөц, байгууллагын болон удирдлагын, мэдээлэл технологийн бүтцийг багтаах;
- (ii) Хөгжлийн төвүүдийн үйлчилгээний дизайныг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, тогтоомжууд, үйлчилгээний техникийн нөхцөлүүдийг тодорхойлох хурдавчилсан үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах; хөгжлийн төвүүдийн үндсэн ажилтнуудын ур чадвар, мэдлэг, туршлагын

талаар үнэлгээ хийх; төслийн аймгууд дах ирээдүйн хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;

- (iii) Хөгжлийн төвүүдэд үзүүлэх хэл засал, ортопед, нийгмийн ажил, бусад нөхөн сэргээх үйлчилгээнд зориулсан үйл ажиллагааны зааврыг боловсруулах; чадавх дээшлүүлэх, дадлагажуулах замаар үйл ажиллагааны зааврыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- (iv) Хэл засал, хөдөлгөөн, ахуй засал, орон зайн баримжаа олгох, ортопед ба нийгмийн ажлын одоо мөрдөж байгаа сургалтын хөтөлбөрийг үнэлэх;
- (v) Хэл засал, хөдөлгөөн, ахуй засал, орон зайн баримжаа олгох, ортопед, нийгмийн ажилтанд зориулсан Гэрчилгээ ба Дипломын сургалтын хөтөлбөрийг боловсруулах/сайжруулах, (үүнд үйлчилгээг цогцоор нь хэрэгжүүлэх кейс менежментийг хэрэгжүүлэх, үнэлгээ хийх, холбон зуучлал, эргэх холбоог сайжруулах зэргийг оруулна);
- (vi) Хэл засал, хөдөлгөөн, ахуй засал, орон зайн баримжаа олгох, ортопед ба нийгмийн ажилд зориулсан сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, шинэчлэх ажилд сонгогдсон сургалтын байгууллагуудад туслалцаа үзүүлэх;
- (vii) Хөгжлийн төвүүдийн хүний нөөцийн төлөвлөгөөг боловсруулах; шинээр боловсруулж/сайжруулсан сургалтын хөтөлбөрийг ашиглан үндсэн мэргэжилтнүүдийг сонгосон сургалтын байгууллагуудтай хамтран сургах;

## В. Нийлүүлэх бүтээгдэхүүн

### Хүснэгт 1. Зорилт 1-4 хүрээнд гол нийлүүлэх бүтээгдэхүүн

Нийлүүлэх бүтээгдэхүүн	
1	Гарааны тайлан, зөвлөх үйлчилгээний нарийвчилсан төлөвлөгөө
2	Улирлын явцын тайлан (Нийт ажлын явц, хэрэгжилтийн өөрчлөлт, саад бэрхшээл хүндрэлүүд болон санал болгосон эсвэл сайжруулах санал)
3	Эцсийн тайлан
<b>Зорилт 1.</b> Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;	
<b>Тусгай зорилт (i)-ийн хүрээнд:</b> Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;	
4	<b>Тайлан 1:</b> Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэх тогтолцоо, хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлтийг хийж буй мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар, эрт үеийн оролцооны хөтөлбөр (портежийг багтаана)-ийн өнөөгийн нөхцөл байдалд түргэвчилсэн үнэлгээ хийх ажлыг удирдах;
5	<b>Тайлан 2:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Шинэчилсэн эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр (Ягаан дэвтэр, насанд тохирсон хүүхдийн хөгжлийн үе шатны стандарчлагдсан ASQ-ийн дагуу), стандарт ажиллагааны заавар;</li> <li>- “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ” / бага дунд, хүнд хэлбэрийн хөгжлийн хоцрогдлыг багтаана/, стандарт ажиллагааны заавар;</li> <li>- ASQ болон BSID-III-д зохиогчийн эрх авах зөвлөмжүүд;</li> <li>- “Хүүхдийн хөгжлийн үе шатны үзүүлэлтүүдийн асуумж”, “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ III”- ийг Монголд нэвтрүүлэхэд хэр боломжтой, найдвартай талаар үнэлгээ хийх бие даан судалгаа хийх багийн ажлын даалгавар;</li> </ul>
6	<b>Сургалтын тайлан 1.</b> <ul style="list-style-type: none"> <li>- “Хүүхдийн хөгжлийн үе шатны үзүүлэлтүүдийн асуумж”, “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ III”, стандарт ажиллагааны зааврыг хэрэгжүүлэхтэй холбоотой мэргэжилтнүүдийг сургах ажлын хүрээнд хийгдэх сургалтын төлөвлөгөө, модуль, гарын авлага, танилцуулга, материалууд; Сургалтын тайлан;</li> </ul>
7	<b>Тайлан 3.</b> <ul style="list-style-type: none"> <li>- Эрт илрүүлэлтийн тогтолцоог хэрэгжүүлэх комиссын ашиглах үйл ажиллагааны удирдамж, зохион байгуулалтын бүтэц, ажлын байрны тодорхойлолт/ажлын удирдамж;</li> <li>- Комиссын чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөө;</li> <li>- Эрт илрүүлэлтийн хяналт, шинжилгээ, үнэлгээний систем;</li> <li>- Эрт илрүүлэлтийг олон нийтэд сурталчлах стратеги;</li> </ul>

<b>Тусгай зорилт (ii)-ын хүрээнд:</b> Эрт боловсролын хөтөлбөр (портеж)-ийг боловсруулж, хэрэгжүүлэх;	
8	<p><b>Тайлан 4.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Шинэчилсэн портеж хөтөлбөр, хэрэгжүүлэх удирдамж, портеж үйлчилгээний ажилчдад зориулсан ажлын тодорхойлолт, портеж үйлчилгээний зардлын тооцоо;</li> <li>- Портеж хөтөлбөрийг ашиглах зохиогчийн эрхийг холбогдох байгууллагуудаас авах зөвлөмж;</li> <li>- Портеж хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний систем;</li> <li>- Тоглоомын номын сангийн талаарх зөвлөмж;</li> </ul>
9	<p><b>Сургалтын тайлан 2:</b> Сургалтын хөтөлбөр, модуль болон сургалтын гарын авлага; Сургалтын тайлан;</p>
<b>Тусгай зорилт (iii)-ийн хүрээнд:</b> Хөгжлийн төвүүдийн үйлчилгээний дизайныг боловсруулах, хөдөлгөөн засал, ахуй засал, хэл засал, орон зайн баримжаа олгох, нийгмийн ажил, ортопед техникч бэлтгэх сургалтын хөтөлбөрүүдийг боловсруул, уг хөтөлбөрүүдийг зохих боловсрол/эрүүл мэндийн байгууллагууд ашиглахад дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх;	
10	<p><b>Тайлан 5:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- ХБИ-дэд үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийн мэргэшлийн ур чадвар, туршлага, ирээдүйн хэрэгцээг тодорхойлсон үнэлгээний тайлан;</li> <li>- Хэл засал, хөдөлгөөн, ахуй засал, орон зайн баримжаа олгох, ортопед ба нийгмийн ажлын одоо мөрдөж байгаа сургалтын хөтөлбөрийг үнэлсэн тайлан;</li> </ul>
11	<p><b>Тайлан 6:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- ХБИ-ийн Хөгжлийн шинэ төвүүдэд зориулсан үйлчилгээний загвар;</li> <li>- Өнөөгийн хууль эрх зүй, стандарт ажиллагааны заавар, үйлчилгээний техникийн тодорхойлолтыг сайжруулах зөвлөмж;</li> <li>- Хэл засал, хөдөлгөөн, ахуй засал, орон зайн баримжаа олгох, ортопед ба нийгмийн ажлын үйлчилгээг хэрэгжүүлэх удирдамж;</li> <li>- Шинээр боловсруулж/сайжруулсан сургалтын хөтөлбөрийг ашиглан Хөгжлийн төвүүдэд ажиллах хүний нөөцийг чадавхжуулах хөгжлийн төлөвлөгөө;</li> </ul>
12	<p><b>Сургалтын тайлан 3:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэл засал, хөдөлгөөн, ахуй засал, орон зайн баримжаа олгох, ортопед ба нийгмийн ажилтан бэлтгэхэд зориулсан Гэрчилгээ ба Дипломын сургалтын хөтөлбөр, сургалтын гарын авлага, модуль; Сургалтын тайлан;</li> </ul>